



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/76

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийн дагуу "Ойн хортон шавж устгал ӨВАХУСЗДТГ/202301003" ажлыг 53,500,000 (тавин гурван сая таван зуун мянга) төгрөгөөр "Гранд Форест" ХХК-иар гүйцэтгүүлэхээр сонгосугай.

2. Дээрх компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ